



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээний газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2021/1/СТА-УТҮГ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. Аудитын тайлан .....	10
3.1. Ерөнхий зүйл .....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	10
3.4. Материаллаг байдал .....	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	12
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	12
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
3.9. Аудитын илрүүлэлт .....	13
Залруулсан алдаа .....	13
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	13
Аудитын зөвлөмж .....	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	15
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	16

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.03.12 № 332  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

ДОРНОД АЙМАГ ДАХЬ РАДИО ТЕЛЕВИЗИЙН  
СҮЛЖЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА  
О.НАМУУНЗУЛ ТАНАА

#### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

##### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээний газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээний газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

##### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

##### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дорнод аймаг дахь радио телевизийн сүлжээний газар нь 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 2021 оны 03 дугаар сарын 09-ны байдлаар дүгнэгдээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

##### Аудитын гол асуудал

1. Тайлант оны эцэст хөрөнгийн тооллого хийсэн комиссын анхан шатны баримт, тайлан байхгүй, үр дүнг тооцоогүй санхүүгийн тайлан баланс илэрхийлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1 дэх "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2.1 дэх "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", "жилийн санхүүгийн тайлан гаргахын

өмнө", 12.2.2 дахь "эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед", УСНББОУС 1-Санхүүгийн тайлангийн толилуулгад нийцэхгүй, оршин байх, эрх ба үүрэг, үнэлгээ, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>270,179,945.48</b>	<b>270,391,112.39</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	269,949.50	1,850,966.56
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	269,949.50	1,850,966.56
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	269,949.50	1,850,966.56
31211	Төрийн сангийн харилцах	269,949.50	1,850,966.56
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	133,286.00	7,374.85
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	133,286.00	7,374.85
3351	Байгууллагаас авах авлага		
3352	Хувь хүмүүсээс авах авлага	133,286.00	7,374.85
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	4,500,000.00	4,500,000.00
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	4,500,000.00	4,500,000.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	4,500,000.00	4,500,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	265,276,709.98	264,032,770.98
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	265,276,709.98	264,032,770.98
35410	Бичиг хэргийн материал	1,152,500.00	1,036,550.00
35420	Аж ахуйн материал	726,318.98	562,999.98
35430	Сэлбэг хэрэгсэл	253,423,931.00	253,301,581.00
35440	Түлш, шатах тослох материал	888,920.00	
35450	Барилгын засварын материал	60,800.00	
35470	Бусад хангамжийн материал	9,024,240.00	9,131,640.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,698,582,082.27</b>	<b>3,698,867,528.55</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3,698,582,082.27	3,698,867,528.55
391	Газар		
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	694,582,082.27	694,867,528.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	647,942,448.50	647,942,448.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	(21,742,883.40)	(43,485,766.80)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	49,436,934.20	49,436,934.20
39204	Хуримтлагдсан элэгдэл	(19,051,025.73)	(24,515,514.96)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,033,028,612.00	1,069,568,612.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,004,113,617.08)	(1,011,838,873.13)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	24,646,541.00	24,646,541.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,564,927.22)	(16,886,852.26)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	3,004,000,000.00	3,004,000,000.00
39301	Програм хангамж	3,300,480.00	3,300,480.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,300,480.00)	(3,300,480.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	3,004,000,000.00	3,004,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,968,762,027.75</b>	<b>3,969,258,640.94</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>10,288,210.60</b>	<b>5,013,154.13</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	10,288,210.60	5,013,154.13
<b>413</b>	<b>Өглөг</b>	10,288,210.60	5,013,154.13
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	6,802,548.60	2,640,028.67
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	3,485,662.00	2,373,125.46
41361	Байгууллагад төлөх өглөг	3,480,662.00	2,373,125.46
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	5,000.00	
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,958,473,817.15</b>	<b>3,964,245,486.81</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,958,473,817.15	3,964,245,486.81
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,842,662,643.85	3,842,662,643.85
51101	Өмч: - төрийн	3,842,662,643.85	3,842,662,643.85
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(425,999,410.45)	(420,227,740.79)
51210	Өмнөх үеийн үр дүн	(425,999,410.45)	(425,999,410.45)
51220	Тайланг үеийн үр дүн		5,771,669.66
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	541,810,583.75	541,810,583.75
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI-IV+V</b>	<b>3,968,762,027.75</b>	<b>3,969,258,640.94</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>304,265,287.76</b>	<b>296,810,331.26</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,542,253.56</b>	<b>2,603,961.26</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,542,253.56	2,603,961.26
120002	Хүүгийн орлого	142,253.56	65,835.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,400,000.00	2,538,125.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,400,000.00	1,350,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,188,125.50
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>302,723,034.20</b>	<b>294,206,370.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	271,786,100.00	294,206,370.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	264,997,900.00	257,361,370.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	6,788,200.00	36,845,000.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	30,936,934.20	-
133003	Хөрөнгийн	30,936,934.20	
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>282,694,107.67</b>	<b>291,038,661.60</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>282,694,107.67</b>	<b>291,038,661.60</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	275,717,107.67	288,333,661.60
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	158,593,965.00	175,592,415.00
210101	Үндсэн цалин	158,593,965.00	175,592,415.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	20,037,681.90	21,857,303.54
210201	Тэтгэврийн даатгал	13,685,277.30	14,910,478.54
210202	Тэтгэмжийн даатгал	1,574,066.82	1,736,705.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,300,332.08	1,389,364.00
210204	Ажилгүйдлийн даатгал	379,777.37	347,341.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,098,228.33	3,473,415.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	24,062,679.00	27,050,587.41
210301	Гэрэл, цахилгаан	17,588,219.00	19,484,061.41
210302	Түлш, халаалт	6,188,460.00	7,566,526.00
210304	Байрны түрээс	286,000.00	
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	10,623,600.33	11,302,938.43
210401	Бичиг хэрэг	210,406.33	460,700.00
210402	Тээвэр, шатахуун	7,345,228.00	9,044,109.46
210403	Шуудан, холбоо, ингернэтийн төлбөр	1,418,185.00	821,309.97
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,649,781.00	10,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		966,819.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	936,136.00	420,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	936,136.00	420,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	8,667,620.00	3,420,960.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	196,200.00	
210604	Урсгал засвар	8,471,420.00	3,420,960.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,861,520.00	1,500,445.00
210702	Дотоод албан томилолт	3,861,520.00	1,500,445.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	16,304,568.00	10,933,958.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамж	7,127,716.00	2,374,892.47
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,967,252.00	7,349,466.03
210807	Газрын төлбөр	1,209,600.00	1,209,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	32,629,337.44	36,254,553.72
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32,629,337.44	36,254,553.72
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	6,977,000.00	2,705,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	6,977,000.00	2,705,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,977,000.00	2,705,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>21,571,180.09</b>	<b>5,771,669.66</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>21,571,180.09</b>	<b>5,771,669.66</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>266,540,153.56</b>	<b>259,965,331.26</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,542,253.56</b>	<b>2,603,961.26</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,542,253.56	2,603,961.26
120002	Хүүгийн орлого	142,253.56	65,835.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,400,000.00	2,538,125.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,400,000.00	1,350,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,188,125.50
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>264,997,900.00</b>	<b>257,361,370.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	264,997,900.00	257,361,370.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	264,997,900.00	257,361,370.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>261,392,061.61</b>	<b>258,384,314.20</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>261,392,061.61</b>	<b>258,384,314.20</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>254,451,061.61</b>	<b>255,679,314.20</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	160,368,125.12	176,822,211.10
210101	Үндсэн цалин	160,368,125.12	176,822,211.10
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	21,496,983.89	24,626,816.22
210201	Тэтгэврийн даатгал	14,531,334.42	18,034,740.22
210202	Тэтгэмжийн даатгал	1,743,860.62	1,596,324.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,384,472.45	1,277,059.00
210204	Ажилгүйдлийн даатгал	412,442.06	319,265.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,424,874.34	3,399,428.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	19,730,903.00	27,589,853.41
210301	Гэрэл, цахилгаан	17,260,143.00	19,484,061.41
210302	Түлш, халаалт	2,184,760.00	8,105,792.00
210304	Байрны түрээс	286,000.00	
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	13,100,021.00	11,096,409.97
210401	Бичиг хэрэг	245,148.00	344,750.00
210402	Тээвэр, шатахуун	10,431,328.00	9,134,110.00
210403	Шуудан, холбоо, ингэрнэтийн төлбөр	1,418,185.00	814,049.97
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,005,360.00	
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		803,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	955,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	955,000.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	18,506,859.00	3,067,320.00
210604	Урсгал засвар	18,506,859.00	3,067,320.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,861,520.00	1,500,445.00
210702	Дотоод албан томилолт	3,861,520.00	1,500,445.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	16,431,649.60	10,406,258.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,126,716.00	1,829,392.47
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,095,333.60	7,367,266.03
210807	Газрын төлбөр	1,209,600.00	1,209,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	570,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		570,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,941,000.00</b>	<b>2,705,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	6,941,000.00	2,705,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,941,000.00	2,705,000.00
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>5,625,100.00</b>	-
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>5,625,100.00</b>	-
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	5,625,100.00	-
222001	Тоног төхөөрөмж	4,500,000.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,125,100.00	
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>5,625,100.00</b>	<b>-</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	5,625,100.00	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	746,958.24	269,949.50
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	269,949.50	1,850,966.56

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,842,662,643.85	541,810,583.75	-425,999,410.45	3,958,473,817.15
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,842,662,643.85	541,810,583.75	-425,999,410.45	3,958,473,817.15
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайланг үеийн үр дүн				0.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,842,662,643.85	541,810,583.75	-425,999,410.45	3,958,473,817.15
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,842,662,643.85	541,810,583.75	-425,999,410.45	3,958,473,817.15
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,842,662,643.85	541,810,583.75	-425,999,410.45	3,958,473,817.15
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайланг үеийн үр дүн			5,771,669.66	5,771,669.66
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,842,662,643.85	541,810,583.75	-420,227,740.79	3,964,245,486.81

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Баглагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	284,904,240.00	258,384,314.20
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	284,904,240.00	258,384,314.20
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	282,191,640.00	255,679,314.20
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	185,671,500.00	176,822,211.00
210101	Үндсэн цалин	185,671,500.00	176,822,211.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	23,208,940.00	24,626,816.22
210201	Тэтгэврийн даатгал	15,782,068.00	18,034,740.22
210202	Тэтгэмжийн даатгал	1,856,715.00	1,596,324.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,485,375.00	1,277,059.00
210204	Ажилгүйдлийн даатгал	371,346.00	319,265.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,713,436.00	3,399,428.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	31,622,400.00	27,589,853.41
210301	Гэрэл, цахилгаан	22,776,000.00	19,484,061.41
210302	Түлш, халаалт	7,320,000.00	8,105,792.00
210303	Цэвэр, бохир ус	840,000.00	
210304	Байрны түрээс	686,400.00	
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	12,548,800.00	11,096,409.97
210401	Бичиг хэрэг	700,000.00	344,750.00
210402	Тээвэр, шатахуун	9,908,800.00	9,134,110.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	840,000.00	814,049.97
210404	Ном, хэвлэл	150,000.00	
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	950,000.00	803,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,600,000.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,600,000.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,830,000.00	3,067,320.00
210604	Урсгал засвар	6,830,000.00	3,067,320.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,500,000.00	1,500,455.00
210702	Дотоод албан томилолт	3,500,000.00	1,500,455.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураангуй</b>	11,210,000.00	10,406,258.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	2,000,000.00	1,829,392.47
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,000,400.00	7,367,266.03
210807	Газрын төлбөр	1,209,600.00	1,209,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6,000,000.00	570,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,000,000.00	570,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	2,712,600.00	2,705,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,712,600.00	2,705,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,712,600.00	2,705,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	284,904,280.00	259,965,331.26
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	270,904,280.00	257,361,370.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	270,904,280.00	257,361,370.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	14,000,000.00	2,538,125.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,350,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,000,000.00	1,188,125.50
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		269,949.50
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		1,850,966.56

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээний газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг О.Намуунзул-д танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 01-ээс 2021 оны 03 дугаар сарын 10-ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээний газрын 2020 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн 07 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээний газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ;
- олон суваг дамжуулах үйлчилгээ;
- олон нийтийн радио, телевизийн үйлчилгээ;
- арилжааны радио, телевизийн үйлчилгээ;
- өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн үйлчилгээ;
- төлбөртэй радио, телевизийн үйлчилгээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээний газар нь 2020 санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Радио телевизийн үндэсний сүлжээний Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар нь 2020 онд харьяа Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээний газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээний газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг үр дүнгийн тайлангийн нийт зардлын 291,038.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 5,820.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээний газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,998,275.8 мянган төгрөгөөр буюу 25,0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	269.9	1,851.0	1,581.0
Авлага	133.3	7.4	-125.9
Урьдчилгаа	4,500.0	4,500.0	-
Бараа материал	265,276.7	264,032.8	-1,243.9
Үндсэн хөрөнгө	3,698,582.1	3,698,867.5	285.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,968,762.0</b>	<b>3,969,258.6</b>	<b>496.6</b>
Өр төлбөр	10,288.2	5,013.2	-5,275.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,958,473.8	3,964,245.5	5,771.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,968,762.0</b>	<b>3,969,258.6</b>	<b>496.6</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,851.0 мянган төгрөг байна.

Авлага дансны үлдэгдэл 7.4 мянган төгрөг болж 125.9 мянган төгрөгөөр буурсан байна. Авлага дансны үлдэгдэл 7.4 мянган төгрөг хувь хүнээс авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 264,032.8 мянган төгрөг болж 1,243.9 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны үлдэгдлээс зарцуулалт хийсэнтэй холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,698,867.5 мянган төгрөг болж 285.4 мянган төгрөгөөр өссөн нь дээд шатны байгууллагаас хөрөнгө шилжүүлэн авснаас шалтгаалжээ.

Биет бус хөрөнгөнд тайланд онд өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 5,013.2 төгрөг байна. Өр төлбөрийн дансны үлдэгдэл 2,640.0 мянган төгрөг нь ажиллагсадтай холбоотой, 2,373.1 мянган төгрөг нь байгууллагад төлөх өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,964,245.5 мянган төгрөг болж 5,771.7 мянган төгрөгөөр өссөн нь дээд шатны байгууллагаас хөрөнгө шилжүүлэн авснаас шалтгаалжээ.

Радио телевизийн сүлжээний газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 7,455.0 мянган төгрөгөөр буюу 2.5 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан дээд шатны байгууллагаас ирүүлсэн үнэ төлбөргүй хөрөнгийн орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 8,344.6 мянган төгрөгөөр буюу 2.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлууд байна. Энэ нь цалин нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 284,904.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 284,904.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 284,904.2 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 284,904.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 270,904.2 мянган төгрөгийг улсын төсвөөс 14,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 257,361.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 2,604.0 мянган төгрөгийн орлого, нийт 259,965.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд бүрэн зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 258,384.3 мянган төгрөг буюу 90.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн данс байхгүй байна.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 111 мэдээлэл хугацаа хоцроон мэдээлсэн байна. Мөн хөрөнгийн 2 ширхэг 36,540.0 мянган төгрөгийн орлогыг www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулаагүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2,690.8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосныг барагдуулсан байна. Аудитаар өгсөн 15,600.0 мянган төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	2,690.8	1	2,690.8			
Албан шаардлага	-	-	-	-			
Зөвлөмж	-	-	-	-			
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>2,690.8</b>	<b>1</b>	<b>2,690.8</b>			

/мянган.төг/

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,107,523.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,387.3 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 5,106,135.7 мянган төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага хүргүүлээ.

#### Залруулсан алдаа

Аудитаар залруулсан алдаа, зөрчил байхгүй болно.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 5,107,523.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1,387.3 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 5,106,135.7 мянган төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

1. Шатахууныг норматив зардлаас 1,387,270 төгрөгөөр илүү зарцуулсан нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны “Жишиг норм батлах тухай” 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-ыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Санхүүгийн тайланд тусгагдсан 4,798,895,015 төгрөг 70 мөнгөний үндсэн хөрөнгө, 264,032,770 төгрөг 98 мөнгөний бараа материалын хөрөнгийн жилийн эцсийн тооллого хийсэн комиссын анхан шатны баримт, тайлан байхгүй, үр дүнг тооцоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн оршин байх, үнэлгээ, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Тайлант оны төсвийн орлогын төлөвлөгөөг 91.5 хувиар буюу 12,811.9 мянган төгрөгөөр дутуу биелүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16.5.2 дахь "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 41.2.1 дэх "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалтуудыг нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

4. Тайлант хугацаанд хийсэн худалдан авалтын 1,148.2 мянган төгрөгийн анхан шатны Е баримтыг хавсаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь заалтад "анхан шатны баримт гэж ....., төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоо", 13.7 дахь хэсэгт "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн Сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 "татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч Е баримтыг хавсаргах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

5. Тайлант хугацааны шатахууны 7,746.8 мянган төгрөгийн замын хуудасны үр дүнг тооцоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" 20.2.6-д "... болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, ..." гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон, үнэлгээ, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

6. Арилжааны банктай хийсэн дансны үлдэгдлийн баталгаанд тусгагдсан орлогын мөнгөн дүнг санхүүгийн тайланд тусгагдсан дүн руу хөөн шалгахад 1,180,447 төгрөгөөр дутуу тусгасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн оршин байх, тохиолдсон байх, толилуулга ба тодруулга, үнэлгээ, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

7. Тайлант Санхүүгийн тайлан тусгагдсан 7.4 мянган төгрөгийн авлага, 5,013.2 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, Элитрүүд ХХК-иас худалдан авсан уурын зуухны үлдэгдэл 5,400.0 мянган төгрөгийг өглөгөөр тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.3-д "бүх өр төлбөр", 20 дугаар зүйлийн 20.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна. байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

8. Элитрүүд ХХК-иас худалдан авсан 9,9 сая төгрөгийн уурын зуухыг орлогод аваагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, иж бүрэн, үнэлгээ, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Дараагийн аудитаар үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

---

#### 4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<b>Радио телевизийн сүлжээний газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2020			ДОА-2021/1/СТА-УТҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Радио телевизийн сүлжээний газар</b>		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шатахууны норматив зардлыг илүү зарцуулсан байна.	1,387.3	Төлбөрийн акт тогтоосон.	Дарга, нягтлан бодогч	О.Намуунзул, А.Мөнх-Оргил
2	Санхүүгийн тайланд тусгагдсан хөрөнгийн тооллыг хийгээгүй.	5,062,927.8	Албан шаардлага хүргүүлсэн.	Дарга, нягтлан бодогч	О.Намуунзул, А.Мөнх-Оргил
3	Тайланд оны орлогын төлөвлөгөөг 91,5 хувиар тасалсан	12,811.9	Албан шаардлага хүргүүлсэн.	Дарга, нягтлан бодогч	О.Намуунзул, А.Мөнх-Оргил
4	Худалдан авалтын Е баримтыг хавсаргаагүй байна.	1,148.2	Албан шаардлага хүргүүлсэн.	Дарга, нягтлан бодогч	О.Намуунзул, А.Мөнх-Оргил
5	Тээвэр шатахууны замын хуудасны тооцоо бодоогүй байна.	7,746.8	Албан шаардлага хүргүүлсэн.	Дарга, нягтлан бодогч	О.Намуунзул, А.Мөнх-Оргил
6	Арилжааны банкт хийсэн дансны үлдэгдлийн баталгаанд тусгагдсан орлогын мөнгөн дүн санхүүгийн тайланд тусгагдсан дүн руу хөөн шалгахад 1,180,447 төгрөгөөр дутуу тусгасан	1,180.5	Албан шаардлага хүргүүлсэн.	Дарга, нягтлан бодогч	О.Намуунзул, А.Мөнх-Оргил
7	Санхүүгийн тайлан тусгагдсан авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй. Мөн Элитрүүд ХХК-иас худалдан авсан уурын зуухны үлдэгдэл төгрөгийг өглөгөөр тусгаагүй	10,420.5	Албан шаардлага хүргүүлсэн.	Дарга, нягтлан бодогч	О.Намуунзул, А.Мөнх-Оргил
8	2019 онд урьдчилгаа төлөн тайлант онд ашиглалтад орсон Элитрүүд ХХК -иас худалдан авсан 9,9 сая төгрөгийн уурын зуухыг орлогод аваагүй байна.	9,900.0	Албан шаардлага хүргүүлсэн.	Дарга, нягтлан бодогч	О.Намуунзул, А.Мөнх-Оргил
9	Хөрөнгийн орлогын гүйлгээг <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> цахим хуудсанд байршуулаагүй	-	Албан шаардлага хүргүүлсэн.	Дарга, нягтлан бодогч	О.Намуунзул, А.Мөнх-Оргил
<b>ДҮН</b>		<b>5,107,523.0</b>			

